

БАТЛАВ.


ЗАХИАЛАГЧ

СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Э.СОНИНТОГОС



НИЙЛҮҮЛЭГЧ

КИБЕРКОМ ХХК –ИЙН ЗАХИРАЛ
Х.БАТПҮРЭВ



СУИС-ИЙН БАДМААРАГ АХЛАХ СУРГУУЛЬД КОМПЬЮТЕР,
ТЕХНИК ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ
Дугаар № [ТХ-03/2017]

Улаанбаатар хот/аймаг


Нэг талаас СОЁЛ УРЛАГИЙН ИХ СУРГУУЛЬ (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас КИБЕРКОМ ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2017 оны 4 сарын 27 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь СУИС-ИЙН БАДМААРАГ АХЛАХ СУРГУУЛЬД КОМПЬЮТЕР, ТЕХНИК ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ ТХ-03/2017-г (цаашид “бараа” гэх) 26,543,000 (Хорин зургаан сая таван зуун дөчин гурван мянга) (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны 26,543,000 (Хорин зургаан сая таван зуун дөчин гурван мянга) төгрөгийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2017 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Гэрээний тусгай нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
СУИС-ИЙН БАДМААРАГ АХЛАХ
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
В.БҮРЭНЖАРГАЛ



СУИС, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр
хороо, СУИС-ийн хичээлийн 3-р байр
Утас: 70123389, 95703311

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
КИБЕРКОМ ХХК –ИЙН МЕНЕЖЕР
П.ХАТАНБААТАР



Чингэлтэй Дүүрэг 2 –р хороо, Энхтайвны
өргөн чөлөө 29/1
Канон Төвийн 4-р давхар
Утас: 70008844, 99099020
Банк: Голомт Банк 1102577333